

СИТИ ИХ СУРГУУЛЬД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. СИТИ их сургуульд оюутан элсүүлэх үйл ажиллагаанд БСШУСЯ- ны сайдын 2013 оны А/79 тоот тушаалын хавсралт "Оюутан элсүүлэх журам"- д нийцүүлэн боловсруулсан энэхүү журмыг баримтлана.

1.2. Оюутан элсүүлэх ажлын гол зорилго нь шалгуулагчдын ерөнхий боловсролын түвшин, мэдлэг, чадвар, авьяасыг бодитойгоор үнэлж, цаашид амжилттай суралцах чадвартай хүмүүсийг шалгаруулан элсүүлэхэд оршино.

Хоёр. Ерөнхий шалгалт

2.1. СИТИ их сургуульд элэх бүрэн дунд боловсролтой иргэн элсэгчийн ерөнхий боловсролын түвшин, мэдлэг, чадварыг тогтоох зорилго бүхий Ерөнхий шалгалт өгнө.

2.2. Ерөнхий шалгалтыг Монгол улсын Боловсролын үнэлгээний төв үндэсний түвшинд зохион байгуулна.

2.3. СИТИ их сургуульд элсэгчийн ерөнхий шалгалтад авсан байх босго оноо 480 – 500 байна.

2.4. Ерөнхий шалгалтын дүнгийн тухай баримт бичиг түүнийг олгосон өдрөөс хойш 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.

Гурав. Оюутан элсүүлэх хөтөлбөр /мэргэжил/- ийн чиглэл

№	Хөтөлбөрийн нэр	Мэргэжлийн чиглэл	Элсүүлэх бүлэг	Босго оноо /Хичээл 1/	Босго оноо /Хичээл 2/
1	Бизнесийн удирдлага. Эрх зүй	Нягтлан бодох бүртгэл	3.2	Нийгмийн тухай мэдлэг 400	Математик 500
		Менежмент	3.1	Нийгмийн тухай мэдлэг 500	Монгол хэл 400
		Маркетинг			
		Худалдаа			
		Эрх зүй			
Зочлох үйлчилгээ /зочид буудал, зоогийн газар/					

		Аялал жуулчлалын менежмент	4.1	Гадаад хэл 400	Газар зүй 500
2	Хүмүүнлэг	Гадаад хэлний орчуулга /англи, хятад, япон, солонгос /	1.1	Монгол хэл 400	Гадаад хэл 480
3	Боловсрол	Багш, гадаад хэлний боловсрол /англи, орос/	1.1	Монгол хэл 400	Гадаад хэл 480
		Багш, сургуулийн өмнөх насны боловсрол	7.1	Монгол хэл 480	-
4	Дизайн	Хувцасны дизайн	6.1	Монгол хэл 480	Ур чадвар 500
		Компьютер, график дизайн			
		Интерьер дизайн			
		Текстилийн үйлдвэрлэлийн технологи /ноос, ноолуур/			
5	Программ хангамж	Программ хангамж	3.2	Нийгмийн тухай мэдлэг 400	Математик 500
6	Архитектур ба барилга	Архитектур	6.2	Математик 480	Ур чадвар 500
		Барилгын инженер	3.2	Нийгмийн тухай мэдлэг 400	Математик 500
7	Урлаг	Дуулах урлаг	6.1	Монгол хэл 480	Ур чадвар 500
		Жүжиглэх урлаг			
		Хөгжмийн урлаг			
		Бүжгийн урлаг			

		Гоо заслын урлаг, технологи	3.1	Нийгмийн тухай мэдлэг 500	Монгол хэл 400
8	Химийн технологи	/Гоо сайхны бүтээгдэхүүний технологи/	5.1	Хими 480	Биологи 400
9	Эрүүл мэнд	Сувилахуй	7.1	Монгол хэл 480	
9	/БНСУ-ын Уюдук их сургуультай 2+2 хамтарсан хөтөлбөр/	Агаарын тээврийн үйлчилгээ	3.1	Нийгмийн тухай мэдлэг 500	Монгол хэл 400

Тайлбар: Ур чадварын шалгалт өгөх элсэгч нь:

а) дуулаач, жүжиглэх урлаг, бүжиглэх урлаг, хөгжмийн урлаг хөтөлбөрт сонсгол, ритм, этюд, дуу, шүлэг, анхаарал, хөдөлгөөний эвсэл буюу бүжгийн ;

б) дизайн, архитектурын хөтөлбөрт хар зургийн шалгалт тус тус өгнө.

Дөрөв. Оюутны элсэлт, сургалтын нөхцөл

4.1. Элсэгч нь тухайн мэргэжлийн чиглэлд харгалзах "Ерөнхий шалгалт"-ыг заавал өгсөн байна.

4.2. Дараах нөхцлөөр хөнгөлөлттэй элсүүлнэ:

- ЭЕШ- д өндөр оноо авсан бол эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг дараах байдлаар хөнгөлнө. Үүнд:
 - 750- аас дээш бол 50%
 - 700- 749 оноотой бол 30%
 - 650- 699 оноотой бол 20%
 - 600- 649 оноотой бол 10%
- Тухайн чиглэлээр аймаг, хот, улсын хэмжээний уралдаан, тэмцээнд эхний 5 байрт шалгарч байсан бол 30 – 40 хувь хүртэл
- СИТИ их сургуулиас суралцах эрхийн урилга хүлээн авсан бол 5-20 хувь хүртэл
- ЕБС- ийг "А" үнэлгээтэй төгссөн бол 30%
- Биеийн тамир спортын өндөр амжилт гаргаж байсан болон спортын зэрэг цолтой бол 20- 50% хүртэл
- Элсэгч нь 8 дугаар сарын 25- ны дотор сургалтын төлбөрөө бүтэн төлвөл 10%, 9 дүгээр сарын 1- ний дотор сургалтын төлбөрөө бүтэн төлвөл 5%- ын хөнгөлөлт эдэлнэ.

Тайлбар: Дээр дурдсан хөнгөлөлтүүд нь хамтарсан хөтөлбөрт хамаарахгүй бөгөөд давхардуулж олгохгүй.

4.3. Элсэхийг хүссэн гадаадын иргэнийг Монгол улсын бүрэн дунд боловсролтой дүйцэх бичиг баримтыг үндэслэн элсүүлнэ.

4.4. Бакалаврын зэргийн боловсролтой иргэн дараагийн дээд боловсрол эзэмших хүсэлтэй бол өмнө нь төгссөн сургуулийн дээд боловсролын дипломыг үндэслэн элсүүлнэ.

Тав. Элсэлтийн үйл ажиллагааны зохион байгуулалт

5.1. Захирлын тушаалаар батлагдсан элсэлтийн комисс элсэлтийн бүхий л үйл ажиллагааг зохион байгуулна. Элсэлтийн комисс нь сургуулийн захиргааны өмнө элсэлтийн үйл ажиллагааг шударга, хууль журмын дагуу явуулах үүрэгтэй.

5.2. Аймаг, орон нутгаас оюутан элсүүлэх ажлыг Монголын их дээд сургуулиудын консерциум / МИДСК /- ын шугамаар зохион байгуулна. Мөн захирлын тушаалаар зарим аймагт элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж болно.

5.3. Оюутан элсүүлэх үйл ажиллагаа нь ил тод, шударга, тэгш байдлыг хангасан байна.

5.4. Элсэлтийн зар сурталчилгаа, үйл ажиллагаа үнэн зөв, ойлгомжтой байж, шалгуулагч бүрэн мэдээлэлтэйгээр сургууль, мэргэжлээ сонгох боломжийг хангасан байна.

5.5. Ерөнхий чиглэлээр эхэлж элсүүлээд, сургалтын явцад нарийвчилсан мэргэжлийн чиглэлээ тогтоох мэргэжилд сургалтын хэд дэх жилээс ямар мэргэжлийн чиглэл сонгох боломжтой талаар элсэлтийн комисс шалгуулагчдыг мэдээллээр хангана.

5.6. Элсэлтийн бүртгэлийн хураамж нь элсэлтийн комиссын бүртгэл хийх, бичиг баримт хүлээн авах, үнэлэх, шалгах зэрэг үйл ажиллагааны зардалд зарцуулагддаг тул элссэн эсэхээс үл хамааран буцаан олгогдохгүй. Харин бүртгэлийн хураамж төлсөн бол сургуулийн санал болгож байгаа бусад мэргэжлийн хөтөлбөрөөс сонгох давуу тал олгогдоно.

Зургаа. Элсэлтийн бүртгэл

6.1. Улаанбаатар хотод элсэгчдийг 2018 оны 06 сарын 01- аас эхлэн өөрийн байранд бүртгэнэ.

6.2. Бүрдүүлэх материал:

- Ерөнхий шалгалтын батламж
- Боловсролын үнэмлэх, гэрчилгээ, диплом
- Сурагчийн хувийн хэрэг
- Иргэний үнэмлэхийн хуулбар
- 3x4 хэмжээний цээж зураг 2%
- Хөнгөлттэй нөхцлөөр элсэх бол холбогдох материал
- Бүртгэлийн хураамж 10000 төгрөг

6.3. Мөн хугацаанд манай сургуулийн албан ёсны веб хуудсаар дамжин элсэх хүсэлт гаргах боломжтой. Үүний тулд:

- а. www.citi.edu.mn – д орж, толгой цэсний сүүлд байрлах “Онлайн бүртгэл” рүү орно.

б. Гарч ирэх цонхонд харагдах нүднүүдэд шаардлагатай мэдээллүүдийг оруулан “Бүртгүүлэх” товчийг дарж хүсэлтээ бүртгүүлнэ.

в. Хүсэлтээ албан ёсны болгон баталгаажуулахын тулд дээр 6.2- т дурдсан бичиг баримтуудыг studentservice@citi.edu.mn мэйлээр илгээх шаардлагатай.

г. Мөн элсэх хүсэлтээ Ерөнхий шалгалтын батламж, Иргэний үнэмлэх болон бүртгэлийн хураамж төлсөн баримтын цахим хуулбарын хамт studentservice@citi.edu.mn мэйл хаягаар явуулж бүртгүүлэх боломжтой.

6.4. Зохих шаардлагыг ханган элсэн орсон оюутан 2017 оны оны 8 дугаар сарын 25- аас 29- ны хооронд сургууль дээр ирж, бүртгүүлэх бөгөөд онлайнаар бүртгүүлсэн элсэгчид 6.2- т дурдсан бичиг баримтуудыг эх хувиар нь авчирч СБЗГ- т өгнө.

6.5. Хэрэв хуурамч бичиг баримт бүрдүүлсэн ба бүрдэл дутуу бол элсэлтийн комисс тухайн элсэгчийг элсэлтийн бүртгэлээс хасах эрхтэй.

Долоо. Элсэлттэй холбоотой маргаан шийдвэрлэх

7.1. Сургуулийн элсэлтийн комисс нь тухайн элсэгчийн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.

7.2. Ерөнхий шалгалттай холбоотой маргааныг сургуулийн элсэлтийн комисс хариуцахгүй.